



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СБА-2024/30-2-ШТА-ГА

Баруун-Урт 2024 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа
Утас: 70518396, Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа
Утас: 70512123, Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор С.Ариунбаяр
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул
Утас: 70512123, Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг
Утас: 70512127, Цахим хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товьёг.....	3
Дүрслэлийн товьёг.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
1.1 Аймгийн ИТХ-ын бүтэц, орон тоог Засгийн газрын тогтоолтой уялдуулан батлаагүй, Төрийн албаны салбар зөвлөл болон ЗДТГ нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна.....	5
Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр нь Монгол улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.....	5
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газрын тогтоолоор баталсан бүтэц, орон тоотой уялдуулаагүй байна.....	6
Хяналт, шалгалтын тоог цөөлөх бодлого орон нутагт хэрэгжихгүй байна.....	10
Төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийж, үр нөлөөг тооцоогүй байна.....	11
Төрийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан хүргэж байна.....	15
Нэг багшид ногдох хүүхдийн тоогоор улсын дундаж үзүүлэлтээс 0.5 нэгжээр их байна.....	16
1.3 Баруун-Урт сумын ЗДТГ-ын албан хаагчдын хэрэгжүүлэх чиг үүрэг давхардсан, төрд учруулсан хохирлыг эрх бүхий албан тушаалтнууд төлөөгүй, мөн төсвийн хүрэлцээ хангамж дутагдалтайгаас төрийн албан хаагчдын нийгмийн хамгааллын хөтөлбөр хангалтгүй хэрэгжсэн байна.....	19
Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, тасгийн ажлын чиг үүрэгт холбогдох аргачлалын дагуу шинжилгээ хийсэн байна.....	19
Боловсрол, эрүүл мэндийн салбарын 2,788 ажилчдад 10,122.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.....	20
Төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалттай холбоотой гомдол маргаан гараагүй байна.....	24
Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учруулсан хохирол бүрэн төлөгдөөгүй байна.....	26
Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн санд албан хаагчийн мэдээллийг дутуу оруулах нийлээ алдаа гарч байна.....	27
БҮЛЭГ2: Төрийн байгууллагууд жендерийн тэгш байдлыг хангах талаар тодорхой бодлого хэрэгжүүлээгүй, албан хаагчдыг сургах төлөвлөгөөг баталсан боловч, хэрэгжилтийг үр дүнтэй тайлагнаагүй, жилийн гүйцэтгэлийн тайланг үр дүнд тулгуурлан тайлагнах үйл явц хангалтгүй байгаагаас албан хаагчдын хөгжлийг дэмжих, тогтвортой ажиллах орчин бүрдүүлэхэд сөрөг үр дагавартай байна.....	28
2.1 Төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, мэргэшсэн албан хаагчдыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөө баталсан боловч, түүний хэрэгжилтийг тайлагнаагүй, төрийн албан хаагчдын 71.6 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.....	28
Төрийн байгууллагууд 2012-2023 онд давхардсан тоогоор 4,505 албан хаагчийн сургалтад хамруулсан бол мэргэшүүлэх багц сургалтад 122 албан хаагч хамрагдсан байна.....	28
Хууль, хүчний байгууллагын мэргэжлийн онцлогоос хамаарч, төрийн албан хаагчдыг сэлгэн болон шилжүүлэн ажиллуулж байна.....	29
Төрийн байгууллага өөрийн нөөц боломжид тулгуурлан мэдээлэл технологийн албан хаагчдыг сургалтад хамруулж байна.....	30
Төрийн албанд жендерийн тэгш байдал харилцан адилгүй байгаа бөгөөд төрийн албан хаагчийн 71.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.....	30
2.2 Төрийн захиргааны байгууллага гүйцэтгэлийн тайланг хүрэх түвшинд үндэслэн тайлагнаагүй, төрийн байгууллагын ил тод байдалд хяналт тавих олон нийтийн зөвлөл томилогдоогүй байна.....	31
E-Mongolia цахим системээр дамжуулан төрийн үйлчилгээг хүргэх нь иргэдийн бодит цагийг хэмнэх, хүнд сурталгүй болгох боломжийг олгож байна.....	31
Байгууллагын гүйцэтгэлийн тайланг зорилт, арга хэмжээ, хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнах ажил хангалтгүй хэрэгжиж байна.....	32
2.3 Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хяналт тавих олон нийтийн зөвлөл томилогдоогүй байгаа ч, төрийн байгууллагууд чиг үүргийнхээ дагуу хамтран ажиллаж байна.....	35
Төрийн байгууллагууд үйл ажиллагааны чиглэлийн дагуу хамтран ажиллаж байна.....	35
Холбогдох байгууллагын санал.....	37
ДҮГНЭЛТ:.....	38
ЗӨВЛӨМЖ:.....	39

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОГ	Байгаль орчны газар
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГЗБТ	Газар зохион байгуулалтын төлөвлөгөө
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
ХҮШХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	5-6
2	сумын ЗДТГ-ын бүтэц орон тоо баталсан шийдвэр	8
3	Төрийн байгууллагын бүтэц, орон тоог баталсан жагсаалт	9
4	цахим хаягийн хандалтын судалгаа	15
5	ЕБС-ийн багшийн ачааллын судалгаа	16-17
6	ЗДТГ-ын хэлтэс нэгжийн хэрэгжүүлэх чиг үүргийн судалгаа	18
7	Эрүү мэндийн салбараас тэтгэмжид хамрагдсан ажилчдын судалгаа	20
8	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийн судалгаа	20-21
9	ХШҮХ-ийн үнэлгээний дундаж	30
10	Аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилт	31

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	14
2	10,000 хүнд ногдох эмч, сувилагчийн тоо	16
3	Төрийн албаны ерөнхий шалгалтын судалгаа	24

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын төлөвлөгөө батлах тухай”, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөөнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумдын ИТХ, ЗДТГ болон төрийн байгууллагуудын 2012-2023 оны хүний нөөцийн баримт бичиг, тушаал шийдвэр түүвэрлэн шалгах, хяналт хийсэн тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, холбогдох бусад баримт бичиг, шийдвэрийг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын талбарын ажлыг ажлыг 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 11 дүгээр сарын 11-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэн батлуулж, 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв

БҮЛЭГ 1. Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогыг Алсын хараа 2050 Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Төрийн албан тухай хууль болон бусад холбогдох хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан журмаар зохицуулж байна.

1.1 Аймгийн ИТХ-ын бүтэц, орон тоог Засгийн газрын тогтоолтой уялдуулан батлаагүй, Төрийн албаны салбар зөвлөл болон ЗДТГ нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр нь Монгол улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

1.1.1.1 Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас төрийн байгууллагын хүний нөөцийн талаар тусгайлан бодлого боловсруулж батлаагүй байна. Харин Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт хүний нөөцийг нэмэгдүүлэх, сургах, мэргэшүүлэх, чадавхжуулах зэрэг 27 зүйл заалт тусгагджээ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хүний нөөцийн талаар дараах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт 1 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ

Хөтөлбөрт хамрах он	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ
2012-2016	АЮУЛГҮЙ ОРЧИНТОЙ МОНГОЛ ХҮН	аюулгүй байдлыг хангах байгууллагын техник хангамжийг сайжруулж, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх; Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх эдийн засгийн тооцооллыг бий болгож, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ.
2016-2020	НИЙГМИЙН БОДЛОГО	Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого баримтална. Үндэсний болон сонгодог урлаг, нүүдлийн соёл иргэншлийг төрийн ивээлд байлгаж, хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, уран бүтээл туурвих, уран бүтээлчдийг урамшуулах санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, монгол хэл, бичгийн соёлыг хадгалах, хамгаалах, судлах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, ном, бүтээл туурвих, соён гэгээрүүлэх монгол өв соёлын дархлааг бий болгох талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
2020-2024	ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	Хууль зүйн салбарын байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмж, дэд бүтцийг шинэчлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.
	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. олон улсад өрсөлдөх чадвар бүхий соёл урлагийн чадварлаг хүний нөөцийг бэлтгэж, ажлын байраар хангах тогтолцоог сэргээнэ.
		Аялал жуулчлалын сургалтын төв байгуулж, салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ.

**ЗАСАГЛАЛЫН
БОДЛОГО**

Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.

Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулж, төрийн албан хаагчийн сургалтын байгууллагын материаллаг орчныг сайжруулж, орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын орчин, дэд бүтэц бий болгоно.

Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглана. Хилчдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хүний нөөцийг нэмэгдүүлнэ. Хилийн анги, салбаруудын автомашины парк шинэчлэлийг үе шаттайгаар хийнэ.

1.1.1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүний нөөцийн зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдан хэрэгжиж байна.

1.1.1.3 Аймгийн Засаг даргын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хүний нөөцийн талаар авч хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн баримт бичиг, МУЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдан эсэхийг авч үзвэл:

1. 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүний нөөцийг бэхжүүлэх, сурган дадлагажуулах талаар зорилт арга хэмжээ тусгаагүй;

2. 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэнд, соёл урлаг, төр захиргааны байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах 4 зорилт, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн;

1.1.1.4 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулсан тул хүний нөөцийн зорилт, арга хэмжээ эдгээр бодлоготой нийцэж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газрын тогтоолоор баталсан бүтэц, орон тоотой уялдуулаагүй байна.

1.1.2.1 Засгийн газрын 2021 оны 376¹ тогтоолоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц орон тоо, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тоог баталсан байна.

1.1.2.2 Аймгийн ИТХ-ын ажлын албанаас Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.4-т зааснаар хүний нөөцийн аудит хийх эрхийг Төрийн албаны зөвлөлд олгосон тул аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлэх боломжгүйг 02/85 албан бичгээр ирүүлсэн тул аудитад хамрагдаагүй.

¹ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай

1.1.2.3 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тооны мэдээллийг санхүүгийн тайлангийн аудитын баримт, материалд үндэслэн авч үзэхэд, Засгийн газрын тогтоол батлагдсанаас хойш ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлаагүй байна. Ажлын алба нь одоогоор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар тогтоолоор баталсан бүтэц, орон тоог мөрдөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

1.1.2.4 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба нь 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар тогтоолоор баталсан 3 хэлтэс, 20 орон тоотой бүтэцтэйгээр нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэвч Засгийн газрын тогтоол гарсантай холбогдуулан уг бүтэц, орон тоог шинэчлэн батлаагүй нь Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2²-т заасантай нийцэхгүй байна.

1.1.2.5 Бүтэц, орон тоог Засгийн газрын тогтоолд нийцүүлээгүйн улмаас илүү ажилчдын цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд жилд дунджаар 20.0-30.0 сая төгрөг зарцуулж байгаа нь төсвийн үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Иймд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ажлын албаны бүтэц, орон тоог Засгийн газрын тогтоолд нийцүүлэх, хүний нөөцөд аудит хийх чиглэлээр Төрийн албаны төв зөвлөлд саналыг уламжлав.

1.1.2.6 Аймгийн ИТХ-ын одоогийн бүтэц нь зохион байгуулалтын хувьд илүү орон тоо бүхий, үр ашиггүй байдлыг үүсгэж, цалин хөлс, урамшуулалд нэмэлт төсөв зарцуулж байна. Үүнээс үүдэн хэмнэлт хийх бодлого хангалтгүй хэрэгжиж, төрийн байгууллагын хууль, тогтоомж зөрчигдсөн нь нутгийн удирдлагын нэр хүндийг сулруулах эрсдэлтэй байна.

1.1.2.7 Сумын ИТХ-ын ажлын алба нь хүн амын тооноос хамааран дээрх тогтоолоор баталсан 3-4 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

1.1.2.8 Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог 55 байхаар тогтоосон байна. Гэвч Аймгийн ЗДТГ-ын даргын 2023 оны А/02 дугаар тушаалаар бүтэц нь дээрх тогтоолын 2 дахь хэсэгт зааснаар, орон тоо нь 62 байхаар батлагджээ. Орон тооны нэмэгдэл нь А/02 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар дараах төрийн үйлчилгээний албан тушаалын орон тоог баталсантай холбоотой байна.

- | | |
|----|---|
| 1. | Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан |
| 2. | Хэвлэл мэдээллийн ажилтан |
| 3. | Сан хөмрөгч |
| 4. | Төрийн архивч |
| 5. | Засаг даргын туслах |
| 6. | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажилтан |

² Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно.

7. Нярав
8. Архивын зааварлагч-арга зүйч
9. Тооцооны нягтлан бодогч

1.1.2.9 Засгийн газрын 377 дугаар тогтоол нь ЗДТГ-ын бүтцийг нарийвчлан заасан боловч албан тушаалуудыг тодорхой заагаагүй байна. Эндээс дүгнэхэд, тогтоолоор баталсан 55 орон тоонд төрийн улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан тушаалууд хамрагдах нь тодорхойгүй байдалд байна. Энэ нь орон тооны бүтэц, албан тушаалын уялдаа холбоо тодорхойгүй болж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд зохион байгуулалтын дутагдал үүсгэх эрсдэлтэй байна.

1.1.2.10 Аймгийн ЗДТГ-ын даргын А/02 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар төрийн улс төрийн, төрийн захиргааны болон тусгай албан тушаалд 54 орон тоог баталсан байна. Дараах хуулиудад заасан орон тоо нь аймгийн ЗДТГ-ын Засгийн газрын тогтоолоор баталсан 55 орон тоонд багтах ёстой боловч, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс төрийн үйлчилгээний албан тушаалуудыг нэмэлтээр баталсан байна. Үүнд:

- *Өрсөлдөөний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт орон нутагт улсын байцаагч буюу төрийн захиргааны заасан байхад “Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажилтан” буюу төрийн үйлчилгээний албан тушаалд;*
- *Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн (шинэчилсэн найруулга) 20³ дугаар зүйлд архивч, сан хөмрөгч, зааварлагч- арга зүйч нь үндсэн орон тоонд багтахар тусгасан байна. Мөн Засгийн газрын тогтоолын 2 дах хэсгийн 2.2-т Хууль эрх зүйн хэлтэс нь архивын тасагтай байна гэж заасан боловч ЗДТГ-ын үндсэн орон тоонд зөвхөн архивын тасгийн орон тоог тусгаж баталсан байна.*

1.1.2.11 Дээрх нөхцөл байдлаас үзэхэд аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог батлахдаа хэлтэс, тасагт зайлшгүй байх албан тушаалуудыг нарийвчлан тогтоож, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах нь зүйтэй байна. Тухайлбал, ЗДТГ-т шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажилтан төрийн үйлчилгээний ангилал, зэрэглэлээр ажиллаж, Өрсөлдөөний тухай хууль зөрчигдсөн тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд холбогдох арга хэмжээ авах, таслан зогсоох зэрэг улсын байцаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

1.1.2.12 Сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг 2009 оны 13 дугаар тогтоолоор тогтоож, 2017 оны 253, 2018 оны 267 дугаар тогтоолоор тус тус өөрчлөн баталсан байна. Сумын ЗДТГ-ын орон тоог доор харуулав:

³ Төрийн архив нь улсын байцаагч, мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан, зааварлагч-арга зүйч, архивч, сан хөмрөгч, мэдээллийн технологийн ажилтан, сэлбэн засагч, баримт ариутгагч болон бусад хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх орон тооны ажилтантай байна.

Хүснэгт 2: сумын ЗДТГ-ын бүтэц орон тоо баталсан шийдвэр

д/д	Сумын нэр	Хүн амын тоо	ЗГ-ын тогтоолоор байвал зохих	Орон тоо баталсан шийдвэр		Баталсан орон тоо
				огноо	дугаар	
1	Асгат	1,941	15	24.01.02	Б/01	16
2	Баруун-Урт	24,328	23	23.01.02	Б/01	29
3	Баяндэлгэр	5,008	18	23.12.17	2//72	23
4	Дарьганга	3,206	16	24.01.15	А/07	21
5	Мөнххаан	4,990	16	22.12.16	А/06	26
6	Наран	1,666	15	23.01.03	А/01/А	15
7	Онгон	3,679	16	23.01.26	А/13	15
8	Сүхбаатар	3,698	16	22.01.20	А/01	19
9	Түвшинширээ	3,437	16	23.12.19	4	21
10	Түмэнцогт	2,468	15	23.01.02	А/01	19
11	Уулбаян	2,808	15	24.01.02	А/01	19
12	Халзан	1,704	15	23.02.17	А/02	17
13	Эрдэнэцагаан	7,062	18	24.01.02	Б/01	20

1.1.2.13 Судалгаанаас үзэхэд, сумын ЗДТГ-ын баталсан орон тоо нь Засгийн газрын тогтоолоор баталсан орон тооноос их байна. Энэ нь Засгийн газрын тогтоолд жишиг албан тушаалуудыг нарийвчилж тусгаагүйгээс сум бүр орон тоог өөр өөр баталсан. Баруун-Урт сумаас бусад сумын төрийн захиргааны албан тушаалын тоо адил байгаа ч төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл харилцан адилгүй батлагдсан байна. Жишээлбэл, Баяндэлгэр, Мөнххаан, Сүхбаатар зэрэг сумууд биеийн тамирын арга зүйч ажиллуулж байхад, зарим сум нийгмийн ажилтан, хэвлэл, олон нийттэй харилцах ажилтан зэргийг төрийн үйлчилгээний албан тушаалд томилон ажиллуулж байна.

1.1.2.14 Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11⁴ дугаар хамтарсан тушаалын хавсралт заасны дагуу багшаас бусад жишиг нормативын дагуу бүтэц орон тоог батлан сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

1.1.2.15 Харин сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүтэц, орон тоог аймгийн Засаг даргын захирамжаар жишиг нормативыг баримтлан баталж сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бол 2024-2025 оны хичээлийн жилд БШУС, Сангийн сайдын 2024 оны А85/ А/34 дүгээр хамтарсан тушаалаар баталсан орон тооны хязгаарыг баримтлан ажиллаж байна.

1.1.2.16 Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын бүтэц, орон тоог холбогдох дээд шатны байгууллага баталсан байна. Төрийн байгууллагын бүтэц, орон тоог баталсан байдлыг доор харуулбал:

⁴ Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив

Хүснэгт 3 Төрийн байгууллагын бүтэц, орон тоог баталсан жагсаалт

д/д	Байгууллагын нэр	Бүтэц, орон тоо баталсан албан тушаалтан	Орон тоо баталсан шийдвэр		Баталсан орон тоо
			огноо	дугаар	
1	Байгаль орчны газар	Засаг дарга	2023.01.19	A/18	33
2	Биеийн тамир, спортын газар	Засаг дарга	2024.01.24	A/39	53
3	Боловсролын газар	БС-ын тушаал	2024.03.20	A/137	32
4	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	ГЗБЗЗГ-ын дарга	2023.01.10	Б/10	33
5	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	ХГБХХЕГ	2024.08.28	Б/199	27
6	Мал эмнэлгийн газар	ХХАХҮЯ- Сайдын тушаал	2023.01.18	A/17	44
7	Нийгмийн даатгалын газар	НДЕГ-ын дарга	2024.04.08	A/51	36
8	Орон нутгийн өмчийн газар	Засаг дарга	2023.11.30	A/663	12
9	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Засаг дарга	2019.02.12	A/55	12
10	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	СЯ Сайд	2023.01.24	A/04	12
11	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	СХЗГ-ын дарга	2024.04.25	A/96	19
12	Статистикийн хэлтэс	ҮСХ	2020.01.02	Б/02	6
13	Татварын хэлтэс	ТЕГ-ын дарга	2024.01.15	A/04	33
14	Улсын бүртгэлийн хэлтэс	УБЕГ-ын дарга	2023.05.24	Б/424	31
15	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	ЦҮОШГ-ын дарга	2023.05.16	A/83	63
16	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	ХХҮЕГ-ын дарга	2023.01.23	A/15	45
17	Хүнс, хөдөө аж ахуйн газар	ХХАХҮЯ- Сайдын тушаал	2023.01.18	A/18	23
18	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	ШШГЕГ дарга	2017.09.19	Б/1153	21
19	Эрүүл мэндийн газар	Засаг дарга	2023.01.19	A/20	38
20	Худалдан авах ажиллагааны газар	Засаг дарга	2023.11.30	A/664	11

Судалгаанаас үзэхэд, ШШГГ-ын бүтэц, орон тоо 2017 оноос хойш шинэчлэгдээгүй бөгөөд тус онд 21 орон тоо батлагдсан байсан ч одоогоор 29 орон тоотой ажиллаж байна. Төрийн байгууллага нь дээд шатны төсөв захирагчаас баталсан бүтэц, орон тооны дагуу иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Хяналт, шалгалтын тоог цөөлөх бодлого орон нутагт хэрэгжихгүй байна.

1.1.3.1 Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны хөтөлбөрийн 6 дахь хэсгийн 3-д (Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоон, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна) хяналт шалгалтын тоог бууруулах зорилт тусгагдсан.

1.1.3.2 Үүний хүрээнд Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын газрыг татан буулгаж, 469 дугаар тогтоолоор мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлсэн байна. Мэргэжлийн хяналтын чиг үүргийг яамдад шилжүүлснээр аж ахуйн нэгжид очих төрийн хяналт, шалгалтын тоо нэмэгдэж, хяналт шалгалтын хэрэгжилтэд хүндрэл үүсэх нөхцөл бий болж байна. Өмнө нь Мэргэжлийн хяналтын газар нэгдсэн удирдамжаар хяналт шалгалт явуулдаг байсан бол одоо салбар бүр тусдаа удирдамжаар хяналт шалгалт

хэрэгжүүлж, энэ нь аж ахуйн нэгжүүдэд зохион байгуулалтын болон үйл ажиллагааны саад бэрхшээл үүсгэж байна. Тухайлбал, Сүхбаатар аймагт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн хяналт шалгалт одоо байгаа байдлаар зохион байгуулалтгүй, хүнд суртал үүсгэсэн байдалтай байна.



Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлсэн нь хяналт шалгалтын давхардал, зохион байгуулалтын саад бэрхшээлийг бий болгож, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд төрийн хяналт шалгалтын тогтолцоог цэгцлэх, салбарын

удирдамжийн уялдаа холбоог сайжруулах, хяналт шалгалтыг хөндлөнгийн нэгдсэн удирдлагын дор зохион байгуулж байх шаардлагатай байна.

1.1.3.3 Салбарын хяналт, шалгалтыг тус тусдаа удирдамжийн дагуу хэрэгжүүлж байгаа нь төрийн хяналт, шалгалтын тоог цөөлөх зорилттой “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны хөтөлбөртэй зөрчилдөж, энэ нь зохион байгуулалтын хүндрэл үүсгэж, аж ахуйн нэгжүүдэд нэмэлт дарамт учруулан хэмнэлт хийх боломжийг хязгаарлаж байна

Төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийж, үр нөлөөг тооцоогүй байна.

1.1.4.1 Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.8-д “төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах” гэж заасны дагуу хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Төрийн албаны зөвлөл хийх эрх олгогдсон байна. Үүний дагуу 2022 оны эхний хагаст аймгийн ЗДТГ-ын дарга, Төрийн албаны салбар зөвлөл хамтран баталсан удирдамжийн дагуу хяналт, шалгалт хийжээ.

1.1.4.2 Хяналт шалгалтын хүрээнд Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнххаан сумдын Засаг даргын Тамгын газарт төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгөөгүй нөөцөд бүртгэлгүй 7 албан хаагч ажиллуулж байгаа зөрчлийг арилгаж, хуульд нийцүүлэх үүрэг чиглэл өгчээ.

1.1.4.3 Төрийн албаны зөвлөл 2012-2023 онд хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, мэдээ аудитад хамрагдаагүй бөгөөд 2024 оны 4 сард хяналт, шалгалт явуулж, хууль, тогтоомж зөрчиж томилогдсон албан хаагчийн шийдвэрийг хүчингүй болгох тогтоол гарган ирүүлсэн байна.

1.1.4.4 Мөн хуулийн 64 дүгээр зүйлд Засгийн газар төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санал, зөвлөмж боловсруулах үүрэг хүлээсэн ч одоогоор хүний нөөцийн бодлогод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нарийвчилсан журам, заавар батлагдаагүй байна.

1.1.4.5 Засгийн газрын 2020 оны 206⁵ дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан нийтлэг журмын 9⁶ дүгээр хавсралт маягтын дагуу хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд дараах шалгуур үзүүлэлтээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр баталжээ. Үүнд:

1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;
2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;
3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;
4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;
5. нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;
6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.

Дээрх шалгуур үзүүлэлтүүдээс харахад, хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх тусгай журам батлагдаагүй нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэхгүй байх шалтгаан болсон байна.

Төрийн албан салбар зөвлөл болон ЗДТГ нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна. Энэ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, төрийн албаны хүний нөөцийн бодлого, үр дүнг дээшлүүлэх санал, санаачилга гарган ажиллах боломжийг хязгаарлаж байна.

1.2 Эмч, эмнэлгийн ажилтны орон тоо нөхөгдөхгүй байгаагаас 10,000 хүн амд ногдох эмч, сувилагчийн тоо улсын дунджаас доогуур, газрын даамалгүй сумдын иргэдийн газар өмчлөх эрх хязгаарлагдаж байгаа нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Төрийн албаны тухай хуулийн заалтуудын зөрчилтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн салбарт эмч, сувилагч, боловсролын салбарт мэргэжлийн багшийн дутагдал байсаар байгаа нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлж байна

⁵ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам

⁶ Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг тайлагнах хүснэгт

1.2.1.1 Сүхбаатар аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн мэдээллийн санд нийт 4,012 төрийн албан хаагч бүртгэлтэй байна. Үүнээс төрийн захиргааны албан тушаалд 492 (12.3%), тусгай албан тушаалд 57 (1.4%), төрийн улс төрийн албан тушаалд 106 (2.7%), төрийн үйлчилгээний албан тушаалд 3,354 (83.6%) хүн ажиллаж байна.

1.2.1.2 Зэвсэгт хүчний анги салбар, Хил хамгаалах, Онцгой байдал, Цагдаа, Шүүх, ШШГГ зэрэг хууль, хүчний байгууллагын хүний нөөцийн мэдээлэл Төрийн албаны зөвлөлийн мэдээллийн санд бүртгэгдээгүй байна. Энэ нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу орон тооны мэдээлэл төрийн нууцад хамаарч байгаатай холбоотой бөгөөд хууль, хүчний байгууллагуудын нэгдсэн судалгаанаас 963 төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагч ажиллаж байна.

1.2.1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 18 аж ахуйн нэгжид нийт 447 ажилтан ажиллаж байгаа бөгөөд ихэнх нь орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авдаггүй, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Орон нутгийн өмчийн оролцоотой эдгээр аж ахуйн нэгжээс 8 нь ус, дулааны хангамжийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байгаа бол 8 нь тохижилт, үйлчилгээ, мод үржүүлгийн чиглэлээр ажиллаж байна.

1.2.1.4 Эрүүл мэндийн салбарт 2023 оны жилийн эцсийн байдлаар 79 орон тоо сул байгаагийн 83.5 хувь буюу 66 нь иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, сувилагч, эх баригчийн орон тоо эзэлж байгаа бөгөөд хүний нөөцийн хангалт дутмаг байгаагаас эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд хүндрэл үүсгэж байна.Тухайлбал

- Эрдэнэцагаан сумын ЭМТ-д эрүүл мэндийн тусламж үзүүлэх 13 орон тоо сул байгаагаас их эмч 3, бага эмч 5, сувилагч 2, эх баригч 2, статистикч 1;
- Уулбаян сумын ЭМТ-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх их эмч 1, бага эмч 4, сувилагч 2, лаборант 1, эх баригч 1 нийт 9;
- Халзан сумын ЭМТ-д бага эмч 3, сувилагч 3, лаборант 1, эм зүйчийн 1 орон тоо тус тус сул байна.

1.2.1.5 Эрүүл мэндийн салбарт хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт хангалтгүй байгаагаас өвчтөнд үзүүлэх эмчилгээний чанар, хүртээмж буурах, ажлын ачаалал нэмэгдэж, үлдсэн ажилтнуудын ядаргаа, стресс ихсэх, иргэдийн сэтгэл ханамж, эмчилгээний үйл явцад хүндрэл үүсэж, урт хугацаанд нийгмийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөр байна.

1.2.1.6 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу сувилагчийн сул орон тоог нөхөх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр сургалтын төлбөрийг төлж, 35 боловсон хүчнийг сургаж байна.

1.2.1.8 ЭМГ-ын төрийн захиргааны албан тушаалд 10 орон тоо сул, нөхөгдөөгүй байна. Сул орон тоог Төрийн албаны салбар зөвлөлөөр дамжуулан

зарлуулж байгаа боловч албан тушаалын тодорхойлолтод заасан орон тоо нөхөгдөхгүй байна. Энэ нь анагаах ухааны чиглэлээр их, дээд сургууль төгссөн боловсон хүчин цалин хөлс, нэмэгдэл урамшууллын хэмжээнээс шалтгаалан эмчийн орон тоонд ажиллах сонирхолтой байгаагаас үүдэлтэй байна.

1.2.1.9 Боловсролын газраас 2023 оны судалгаагаар үндсэн багшийн 73, түр буюу захиргааны чөлөөтэй (жирэмсний амралт) 14 багшийн орон тоо сул байгаагаас гадна сэтгэл зүйч, хоол зүйч, эмч, нийгмийн ажилтан, сургалтын менежер зэрэг 20 орон тоо мөн нөхөгдөөгүй байна. Түүнчлэн, англи хэлний багшийн орон тоо 10, монгол хэл, уран зохиолын багш 12, түүх, нийгэм судлалын багш 10, математикийн багш 10, биеийн тамирын багш 5, бага ангийн багш 7, бусад хичээлийн багш 33 дутагдалтай байна.

1.2.1.10 Багшийн сул орон тоо нөхөгдөхгүй байгаа нь багшийн ажлын ачаалал нэмэгдэх, сурагчдад шаардлагатай мэдлэгийг хангалттай хүргэх боломжгүй болсноор хичээлийн дундаж үнэлгээ буурах, хичээлээс гадуурх секц, дугуйлан хичээллэх цаг хязгаарлагдах зэрэг сөрөг үр дагавартай болж байна. Энэ нь, сурагчдын сургалтын чанар, боловсролын үр дүнд сөргөөр нөлөөлөх бөгөөд ЕБС-ийг багшлах боловсон хүчнээр хангах бодлогыг орон нутгийн удирдлага, салбарын яам хамтран зохион байгуулах шаардлагатайг илтгэж байна. Харин сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 40 орон тоо сул байгаагаас 13 буюу 32.5 хувь нь багшийн орон тоо эзэлж, дуу хөгжмийн багшийн сул орон тоо 9 байна.

1.2.1.11 Боловсрол, эрүүл мэнд болон соёлын байгууллагаас бусад төрийн байгууллагын хувь 2023 оны байдлаар 25 орон тоо сул байна. Үүнээс ГХБХБГ-т газрын даамлын орон тоо 5, Мал эмнэлгийн газарт мал аж ахуйн менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтний орон тоо 6, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хөдөлмөрийн улсын байцаагч 1, сумын халамжийн мэргэжилтний орон тоо 2 байна.

1.2.1.12 Төрийн байгууллагууд батлагдсан бүтцийн хүрээнд ажиллаж чадахгүй байгаа нь төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэхэд хүндрэл үүсгэж, энэ нь иргэдийн эрх зөрчигдөхөд хүргэж байна. Жишээ нь, иргэд шаардлагатай төрийн үйлчилгээг цаг хугацаанд нь авч чадахгүй, үйлчилгээний чанар буурч байгаа нь тэдний эрхийг ноцтойгоор хязгаарлаж байна. Тухайлбал


- ГХБХБГ-ын сумын газрын харилцааны асуудал хариуцсан даамлын орон тоо сул байгаа нь тухайн жил хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ГЗБТ хангагдахгүй, иргэн хуульд заасан газар өмчлөх, гэр бүлийн хэрэгцээнд газар эзэмших асуудал орхигдож эрх нь зөрчигдөж байна.

1.2.1.13 Иймд орон нутгийн түвшинд хүний нөөцийн бодлогыг боловсруулж, орон нутгийн төсөвт шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг үе шаттайгаар төлөвлөн батлуулж, төрийн байгууллагуудыг хүний нөөцөөр хангах талаар дээд шатны байгууллага, Засгийн газар, салбарын яамтай хамтран ажиллах нь зүйтэй байна.

Төрийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагааг олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан хүргэж байна.

1.2.2.1 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд, төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах зохицуулалтыг тусгасан байна. Мөн хуулиар Шилэн дансны тухай хуулийн хүрээнд цахим системд байршуулбал зохих мэдээллийг давхар зохицуулсан байна.

1.2.2.2 Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн үнэлгээ, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын дүнгээс үзэхэд орон нутгийн төрийн захиргааны болон төсвийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдал 2019-2023 оны дунджаар 88.4 гэж үнэлэгджээ. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээг он тус бүрээр харуулбал: График 1



1.2.2.3 Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206⁷ дугаар тогтоолын хавсралтаар баталсан нийтлэг журмын 9 дүгээр маягтад заасан 46 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн байна. Үнэлгээний дундаж 2023 он хамгийн өндөр байгаа бол 2021 он хамгийн бага буюу 86.7 хувьтай үнэлэгдсэн байна.

1.2.2.4 Сүүлийн жилүүдэд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг facebook болон page хуудсаар дамжуулан хүргэж байгаа нь иргэд мэдээ мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэх сайн талтай байна. Тухайлбал төрийн байгууллагуудын өөрийн цахим хаягт мэдээлэл байршуулсан байдлыг харуулбал:

⁷ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР
ТЭТГЭМЖ: ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖИЙН ОЛГОЛТ

2024 оны 10 дугаар сар

- Нийгмийн халамжийн тэтгэвэр**
Хүний тус: 100,000
Мөнгөн дүн: 1,000,000.00
- Алдарт цааштай ажил хийгээд олгох хөнгөлөлт, тусламж**
Хүний тус: 20,000
Мөнгөн дүн: 200,000.00
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хамгаалалт**
Хүний тус: 50,000
Мөнгөн дүн: 500,000.00
- Хүндрэхийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ**
Хүний тус: 100,000
Мөнгөн дүн: 1,000,000.00
- Олонд нийтийн дунд нэр хүндтэй**
Хүний тус: 100,000
Мөнгөн дүн: 1,000,000.00
- Цалингийн эхний тэтгэвэр**
Хүний тус: 100,000
Мөнгөн дүн: 1,000,000.00
- Хүүхдийн нөхөн тэтгэвэр**
Хүний тус: 100,000
Мөнгөн дүн: 1,000,000.00
- Олон нийтийн оролцоонд тусалсан халамжийн үйлчилгээ**
Хүний тус: 100,000
Мөнгөн дүн: 1,000,000.00

АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

Сүхбаатар аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар

Тавигдах шаардлага:

- Программ хангамж, IT, компьютер график дизайн, мэдээлэл технологийн мэргэжилтэй
- Дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах чадвартай.
- Photoshop, Indesign, Adobe Premiere болон хэрэглээний программ дээр ажиллах, компьютер засварлах чадвартай
- Ачаалал даах чадвартай, төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ: Төрийн албан хаагчийн анкет, дипломын хуулбар

Хугацаа: 2024 оны 10 дугаар сарын 03

Хаяг: ХГБХХГ

99016955, 99082100



Сүхбаатар Аймаг Нийгмийн Даатгал

10 Jun

- ✓ Нийгмийн даатгалын байгууллага үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор улсын хэмжээнд КоллПро үйлчилгээг нэвтрүүлж байгаа бөгөөд Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын газар нь тус үйлчилгээг нэвтрүүлээ.
- ☎ Даатгуулагч та 70518351 дугаарт холбогдон харгалзах товч дээр дарж өөрт хэрэгтэй мэдээллээ авна уу.

НЭЭЛТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд дараах мэргэжлийн хүмүүсийг сонгон шалгаруулж авна

ҮҮНД:

- ✓ Их эмч
- ✓ Сувилагч, тусгай мэргэжилтэн
- ✓ Эм зүйч
- ✓ Эрх зүйч
- ✓ Нийгмийн ухаан сэтгэл судлаач

Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын төлөөлөл

Шалгуур:

- Анагаах ухаан, эрх зүй, хүний эрх, нийгмийн ухаан, сэтгэл судлалын чиглэлээр мэргэшсэн, тухай мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан, мэргэжил нэгт болон үйлчлүүлэгч олон нийтийн дунд нэр хүндтэй
- Ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдсан (Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдсан буюу ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно)
- Ёс зүйн зөрчилд холбогдож байгаагүй
- Ёс зүйн чиглэлээр ажиллах сонирхолтой

Бүрдүүлэх материалын жагсаалт:

- Төрийн албан хаагчийн анкет
- Мэргэжлийн үнэмлэхийн хуулбар
- Дипломын хуулбар /нотариатаар баталгаажуулсан/
- Ажлын газрын тодорхойлолт

Материалыг 2024 оны 12 сарын 09 ны өдрийг дуустал Эрүүл мэндийн газрын 305 тоот өрөөнд хүлээн авна.

Утас: 99161411

1.2.2.5 Хамгийн их үйлчилгээ үзүүлдэг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон анхааруулах мэдээ хамгийн их хүргэдэг УЦУОШГ-ыг сонгон, цахим хуудсаар хүргэсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд мэдээлэл иргэдэд дараах байдлаар хүрсэн байна.

Хүснэгт 4 цахим хаягийн хандалтын судалгаа

№	Цахим хаяг	Дагагчийн тоо	Нийтлэл	Хандалт
1	https://www.facebook.com/SBXXYGazar/	1,917	239	99,200
2	https://www.facebook.com/Sukhbaatar.HHUGazar	5,357	273	82,350
3	https://sukhbaatar.hudulmur-halamj.gov.mn/ сайт		183	1,680
4	Сүхбаатар аймгийн Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төв	2,100		
5	Sukhbaatar aimag TsagUur	5,000	78	83,525

1.2.2.6 Дээрх 2 байгууллагын үйл ажиллагааг Facebook цахим хуудсаар дамжуулан хүргэх нь иргэдэд түргэн шуурхай хүрч байгаа бол цахим сайтаар нийтэлсэн мэдээлэл иргэдэд хүрэхэд удаашралтай байна. Тухайлбал <https://sukhbaatar.hudulmur-halamj.gov.mn/> сайтад 183 мэдээлэл нийтэлсэн байхад 1,680 хандалттай байгаа бол facebook хуудсаар 239 мэдээллийг 99,200 иргэнд хүрснээс харж болох юм.

Нэг багшид ногдох хүүхдийн тоогоор улсын дундаж үзүүлэлтээс 0.5 нэгжээр их байна.


1.2.3.1 Сүхбаатар аймгийн 65 мянга гаруй иргэнд 130 төрийн байгууллага үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс төрийн захиргааны 28, төрийн байгууллага 15,

боловсролын салбарын 44, эрүүл мэндийн салбарын 16, соёлын салбарын 15, тусгай чиг үүргийн 12 байгууллага тус тус үйл ажиллагаа явуулж байна.

1.2.3.2 Эрүүл мэндийн болон боловсролын салбарын ажилчдын хүртээмжийн судалгааг Үндэсний статистикийн хорооны 1212.mn цахим сайтын мэдээлэлд үндэслэн хийхэд дараах үр дүн гарч байна.

1.2.3.3 Эрүүл мэндийн салбарын 10,000 хүн ам тутамд ногдох эмч, сувилагчийн тоог улсын болон хөрш аймгийн үзүүлэлтэй харьцуулж үзэхэд 2023 оны байдлаар Сүхбаатар аймгийн хэмжээнд 396 хүн ам тутамд 1 эмч, 279 хүн ам тутамд 1 сувилагч ногдож байна. Эмч, сувилагчийн хүрэлцээний судалгааг 2020-2023 оны байдлаар харуулбал.

График 2



1.2.3.4 Судалгаанаас үзэхэд, улсын дундаж үзүүлэлтээр 10,000 хүн ам тутамд 44.3 эмч, 42.8 сувилагч ногдож байгаа бол Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд ачаалал ихтэй байгааг харуулж байна. Энэ нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг оновчтой төлөвлөх, эмч, эмнэлгийн ажилтны тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэж байна.

1.2.3.5 Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа багшийн ачааллыг хөрш аймаг болон улсын дундажтай харьцуулж үзэхэд 2023 оны байдлаар 1 багшид ногдох хүүхдийн тоо улсын дундаж болон Хэнтий аймгийн дунджаас 0.5-1.4 нэгжээр их байгаа бол Дорнод аймгаас 0.7 нэгжээр бага байна.

Хүснэгт 5 ЕБС-ийн багшийн ачааллын судалгаа (нэг багшид ногдох хүүхдийн тоогоор)

Он	Улсын хэмжээнд		Сүхбаатар		Дорнод		Хэнтий	
	нийт багшид ногдох	бага ангийн багшид	нийт багшид ногдох	бага ангийн багшид	нийт багшид ногдох	бага ангийн багшид	нийт багшид ногдох	бага ангийн багшид
2012 он	18.5	27.6	19.5	27.2	17.5	25.4	17.8	23.6
2013 он	18.3	27.2	19.0	26.9	17.4	25.8	17.7	23.6

2014 он	18.4	28.2	19.1	26.7	17.9	26.8	17.9	23.7
2015 он	18.8	27.5	19.2	27.4	17.7	26.8	17.5	23.4
2016 он	19.1	28.9	20.4	29.7	18.5	29.1	18.9	26.0
2017 он	19.6	30.2	20.2	30.4	18.9	29.9	19.7	27.0
2018 он	19.5	30.5	20.1	30.5	19.3	30.9	19.0	26.8
2019 он	20.0	31.1	20.2	30.4	20.1	31.6	20.0	27.4
2020 он	20.0	31.1	20.6	30.8	20.2	31.7	19.9	27.5
2021 он	20.3	31.4	20.9	31.3	20.9	32.1	20.2	27.8
2022 он	20.7	31.6	21.4	31.0	21.4	32.2	20.5	28.3
2023 он	20.9	31.0	21.4	30.7	22.1	33.3	20.0	27.7

(Эх сурвалж: 1212.мн)

1.2.3.6 Судалгаанаас харахад Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 онд нийт багшид ногдох хүүхдийн тоо 2012 оныхоос 1.9, бага ангийн багшид ногдох хүүхдийн тоо 3.5 нэгжээр өссөн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд сургуулийн насны хүүхдийн тоо эрчимтэй нэмэгдэж байгаа хэдий ч сургуулийн тоо нэмэгдээгүйтэй холбоотой байна.

1.2.3.7 Сумын ЕБС-ийн нэг багшид ногдох хүүхдийн тоонд судалгаа хийхэд, хүн ам олонтой Эрдэнэцагаан сумын нэг багшид ногдох хүүхдийн тоо аймгийн 2023 оны дундаж үзүүлэлтээс 3.4 нэгжээр их байгаа бол, хүн ам цөөнтэй Асгат, Наран, Халзан сумдын нэг багшид ногдох хүүхдийн тоо дундаж үзүүлэлтээс 2.8-5.4 нэгжээр цөөн байна.

1.2.3.8 Бусад төрийн байгууллагуудаас онцлон дурдвал, ХХҮГ-ийн үйлчилгээ иргэдэд хүртээмжтэй байгаа эсэхийг харьцуулан үзэхэд тус газар аймгийн хэмжээнд халамжийн 10 хөтөлбөрийн 72 үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн 50 хөтөлбөрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Баруун-Урт сумаас бусад суманд хөдөлмөр, халамжийн хөтөлбөрийн дээрх үйлчилгээг 1 албан хаагч хариуцан гүйцэтгэж байгаа бөгөөд энэ нь албан хаагчийн ажлын ачаалал хэт ихсэж, ажлын ихэнх цагийг халамжийн үйлчилгээнд зарцуулснаас хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа тухайн суманд орхигдох эрсдэлтэй байна. Иймд төрөөс үзүүлж буй халамжийн бодлогыг цөөлж, халамж болон хөдөлмөр эрхлэлтийг суманд жигд хүртээмжтэй байхаар хүний нөөцийн бодлогыг тодорхойлох шаардлагатай байна.

1.2.3.9 Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт сумын ИТХ-ын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан тушаал эрхэлж болохоор заасан. Энэ нь сум орон нутагт хүний нөөц хүрэлцээ, хангамж дутагдалтай байдагтай холбоотой боловч Төрийн албан тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.5⁸, 49 дүгээр зүйлийн 49.3⁹ дахь хэсэгт зааснаар төрийн албан хаагч улс төрийн гишүүн байх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, дайчлагдахыг хориглосон заалттай зөрчилдөж байна.

⁸ улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох;

⁹ Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд дайчлах, чиг үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

1.3 Баруун-Урт сумын ЗДТГ-ын албан хаагчдын хэрэгжүүлэх чиг үүрэг давхардсан, төрд учруулсан хохирлыг эрх бүхий албан тушаалтнууд төлөөгүй, мөн төсвийн хүрэлцээ хангамж дутагдалтайгаас төрийн албан хаагчдын нийгмийн хамгааллын хөтөлбөр хангалтгүй хэрэгжсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын хэлтэс, тасгийн ажлын чиг үүрэгт холбогдох аргачлалын дагуу шинжилгээ хийсэн байна.

1.3.1.1 Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377¹⁰ дугаар тогтоолын 5 дахь хэсэгт аймгийн ЗДТГ-ын хэлтэс, тасаг, эрхлэх асуудлын хүрээний агентлаг хооронд чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохион байгуулахыг аймгийн Засаг даргад, 376¹¹ дугаар тогтоолын 5 дахь хэсэгт аймгийн ИТХ-ын ажлын албаны чиг үүргийн шинжилгээ хийхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус зөвлөсөн.

1.3.1.2 Аймгийн ЗДТГ нь нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлт, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, төрийн байгууллага зэрэг 12 ерөнхий чиг үүргийн хүрээнд хэлтэс, тасгийн 225 дэд чиг үүргийг тодорхойлж баталсан байна. Чиг үүргийн шинжилгээ хийсэн байдлыг хэлтэс тус бүрээр дараах байдлаар харуулбал:

Хүснэгт 6 ЗДТГ-ын хэлтэс нэгжийн хэрэгжүүлэх чиг үүргийн судалгаа

д/д	Хэлтсийн нэр	Хэрэгжүүлэх чиг үүргийн тоо		
		ерөнхий	үндсэн	дэд
1	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	5	22	121
2	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	1	3	8
3	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	2	5	19
4	Санхүү, төрийн сангийн хэлтэс	1	4	20
5	Нийгмийн бодлогын хэлтэс	2	6	44
6	Хууль, эрх зүйн хэлтэс	1	4	13
	НИЙТ ДҮН	12	44	225

1.3.1.3 Дээрх судалгаанаас үзэхэд, ЗДТГ-ын нийт хэрэгжүүлэх чиг үүргийн 53.8 хувь буюу 121 чиг үүрэг нь ХБТХОХ-тэй холбоотой байгаа бөгөөд ажлын байрны зураг авалтын тайлан болон бусад баримт материалаас үзэхэд тус хэлтэс нь 8 яамны 10 салбарын орон нутгийн бодлого, төлөвлөлтийг хариуцан ажиллаж байна. Мөн дээр дурдсан салбаруудын харьяа ХХААГ, МЭГ, БОГ, ГХБХБГ зэрэг агентлагууд орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа бол уул уурхай, эрчим хүчний салбарын бодлогыг 1 албан хаагч хариуцан ажиллаж байна. Үүнээс үзэхэд, уг хэлтсийн ажлын ачаалал бусад хэлтсүүдээс илүү байгааг ажиглаж болно.

1.3.1.4 Харин Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны чиг үүргийн шинжилгээг хийхийг зөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй байна.

¹⁰ Аймгийн Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай

¹¹ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай

1.3.1.6 Аймаг, сумын ЗДТГ-ын албан тушаалын тодорхойлолтыг түүвэрчлэн авч, хэрэгжүүлэх чиг үүрэгт дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарсан. Үүнд

- Засгийн газрын тогтоолоор ОНХС-ийн хариуцсан мэргэжилтний орон тоог 2023 оноос нэмэгдүүлсэн бөгөөд одоогоор албан тушаалын тодорхойлолт батлагдаагүй байна.

- Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан гэсэн 2 орон тооны хэрэгжүүлэх чиг үүрэг давхардсан байна.

1.3.1.7 Баруун-Урт сумын ЗДТГ-ын батлагдсан бүтэц, орон тооны албан тушаалын тодорхойлолтыг түүвэрчлэн авч үзэхэд, хэрэгжүүлэх чиг үүрэг нь өөрийн болон бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардаж байна. Тухайлбал:

- Газар зохион байгуулалт, барилга, дэд бүтэц хариуцсан мэргэжилтний чиг үүрэг газрын даамал, аймгийн ЗДТГ-ын барилга, хот байгуулалт, газрын харилцааны бодлогын ахлах мэргэжилтний чиг үүрэгтэй давхардсан;

- Зохион байгуулалт-үйлчилгээний тасгийн даргын хэрэгжүүлэх чиг үүрэг ЗДТГ-ын даргын чиг үүрэгтэй давхардсан;

- Үйлчилгээний төвийн ахлах ажилтны хэрэгжүүлэх чиг үүрэг нь багийн засаг дарга, зохион байгуулагчийн үйл ажиллагааг хянахтай зэрэгцэн, зорилт, чиг үүрэгтэй давхардаж байна.

1.3.1.8 Иймд чиг үүргийн давхардал үүсэж байгаа албан тушаалуудыг нэгтгэн, Төрийн албаны зөвлөлөөс баталсан сумын ЗДТГ-ын албан хаагчдын жишиг албан тушаалын тодорхойлолтыг баримтлан, албан тушаалын давхардал, хийдэл үүсгэхгүй байх нь зүйтэй байна. Үүний дагуу, Баруун-Урт сумын ЗДТГ-ын албан хаагчдын зорилт, чиг үүргийн давхардлыг арилгах, хүний нөөцөд аудит хийх чиглэлээр салбар зөвлөлд албан шаардлага хүргүүлээ.

1.3.1.9 Монгол Улсын Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай хуулийн (2020 оны шинэчилсэн найруулга) 67 дугаар зүйлийн 67.3¹² дахь хэсэгт ЗДТГ-ын даргыг хугацаатай томилохоор заасан байна. Гэвч хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш томилогдсон аймгийн болон Асгат, Баяндэлгэр, Наран сумын ЗДТГ-ын даргыг томилсон шийдвэрт хугацааг тусгаагүй байна. Иймд аймаг болон дээрх сумдын ЗДТГ-ын даргыг томилсон шийдвэрт хугацааг тусгаж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын 2,788 ажилчдад 10,122.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

1.3.2.1 Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлээс 62 дугаар зүйлд төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нөхөн төлбөр, нийгмийн баталгааг хангах зохицуулалтыг тусгасан байна.

¹² Тамгын газрын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж, Засаг дарга зургаан жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.

1.3.2.2 Төрийн байгууллагууд албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, нөхөх олговрыг Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр олгож байгаа боловч хууль эрх зүйн актаар зохицуулагдаагүй тусламж, дэмжлэгийг байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлсэн нь хууль, тогтоомжид нийцэхгүй байна.

1.3.2.3 Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.6-т /ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах бол ирэх, очих замын зардлыг, эсхүл магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилалд сувилуулах бол ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож хоёр жилд нэг удаа олгох;/ тусгажээ. Гэтэл УИХ-аар 2022 онд батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 (Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон)-т зааснаар уг төрлийн тэтгэмжид хөрөнгө зарцуулахыг хориглосон байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлээр зохицуулсан хориглосон заалт нь Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасантай нийцэхгүй заалт байжээ. Үүнээс үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу нөхөх төлбөрт хамрагдах төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн байна.

1.3.2.4 Эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон багш, сургууль, цэцэрлэгийн удирдах албан тушаалтан, туслах багш нарт хуульд заасны дагуу 3-5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгож байна.

1.3.2.5 Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5¹³ заасан тэтгэмж болон тэтгэвэр гарахад нэг удаа олгосон тэтгэмжийн байдлыг 2012-2023 оны байдлаар харьцуулж харуулав.

Хүснэгт 7 Эрүүл мэндийн салбараас тэтгэмжид хамрагдсан ажилчдын судалгаа

ОН	Хөдөө орон нутгийн тэтгэмж авсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо		Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж авсан эмч эмнэлгийн мэргэжилтний тоо, дүн	
	тоо	Мөнгөн дүн /сая төгрөг/	тоо	Мөнгөн дүн /сая төгрөг/
2012 он	136	511.8	21	131.6
2013 он	54	140.4	24	294.1
2014 он	92	247.4	21	312.1
2015 он	25	79.4	20	282.7
2016 он	59	191.5	7	115.5
2017 он	257	845.7	17	283.0
2018 он	91	284.6	30	402.6
2019 он	80	247.0	7	113.4
2020 он	135	557.4	17	293.0

¹³ Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэнд гурван жил тутамд нэг удаа зургаан сарын, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эмнэлгийн бусад мэргэжилтэнд таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас нь олгоно.

2021 он	86	377.4	10	215.7
2022 он	134	635.1	23	535.3
2023 он	130	828.2	40	984.8
ДҮН	1,279	4,946.1	237	3,963.9

1.3.2.6 Судалгаанаас үзэхэд хөдөө орон нутагт ажилласны 5 жил тутамд олгох тэтгэмжийг давхардсан тоогоор 1,279 эмч, эмнэлгийн ажилтанд 4,946.1 сая төгрөгийг олгосон байна.

1.3.2.7 Боловсролын газраас авсан судалгаагаар 2014-2023 онд 1,509 багш, ажилчдад хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмж 5,176.6 сая төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 8 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийн судалгаа

д/д	ОН	ЕБС-ийн тэтгэмж авсан багш, ажилчдын тоо		Цэцэрлэгийн тэтгэмж авсан багш, ажилчдын тоо	
		тоо	мөнгөн дүн /сая төгрөгөөр/	тоо	мөнгөн дүн /сая төгрөгөөр/
1	2014	218	378.9	46	132.9
2	2015	24	78.8	18	44.9
3	2016	47	166.2	9	28.1
4	2017	275	955.3	63	203.9
5	2018	108	335.5	92	266.5
6	2019	119	397.7	61	191.3
7	2020	-	-	4	19.2
8	2021	66	280.4	39	111.7
9	2022	17	82.7	77	359.5
10	2023	132	677.1	94	466.0
НИЙТ ДҮН		1,006	3,352.6	503	1,824.0

1.3.2.8 Судалгаанаас үзэхэд, төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор багш, ажилчдад олгож буй мөнгөн тэтгэмж 2014 онтой харьцуулахад 3 дахин нэмэгдсэн байна.

1.3.2.9 Насан туршийн суралцахуйн төв нь 8 орон тоотойгоор чиг үүргээ хэрэгжүүлж байгаа боловч төсөвт томилолтын зардал батлагдаагүйгээс Улаанбаатар хот болон аймаг, сумдад томилолтоор ажилласан албан хаагчдын нөхөн олговрыг олгох боломжгүй байна. Тухайлбал 2024 он гарсаар тус төвийн 6 албан хаагч Улаанбаатар хот, Хэнтий аймаг болон сумдад 39 хоног томилолтоор ажилласан байхад томилолтын нөхөн олговор олгоогүй байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1¹⁴-т заасантай нийцэхгүй байна. Иймд тус төвийн удирдлага томилолтоор ажилласан албан хаагчдын нөхөн олговрыг дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэн албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

1.3.2.10 Аймгийн Засаг дарга, түүний ажлын албанаас төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах зорилгоор 2023-2027 онд хэрэгжүүлэх “Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах” дунд хугацааны

¹⁴ Албан томилолтын зардлыг

хөтөлбөрийг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02 өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолоор баталсан байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эрүүл мэнд, боловсролын салбарын 8 албан хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор 140.0 сая төгрөгийг олгосон байна.

1.3.2.11 Төрийн байгууллагын албан хаагчдын нэмэгдэл урамшуулал, тэтгэмж хууль, тогтоомжид нийцсэн эсэхийг түүвэрчлэн үзэхэд хууль, эрх зүйн актад тусгагдаагүй цалингийн нэмэгдэл, урамшуулал, тэтгэмж олгосон, хөдөлмөрийн гэрээгүй албан хаагчдад цалин хөлс, урамшуулал олгосон, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээс өөр ажил гүйцэтгүүлэхээр томилон ажиллуулсан, томилолтын нөхөн олговрыг зохих журмын дагуу олгоогүй байна. Тухайлбал:

- Аймгийн ЗДТГ-аас албан хаагчдыг зүүн бүсийн тэмцээнд оролцуулахаар Дорнод аймагт томилон ажиллуулж, томилолтын зардалд 14.8 сая төгрөг зарцуулжээ. Тус тэмцээнд амжилттай оролцож, багаараа шагналт байрт шалгарсан тул нийт ажилчдад 13.5 сая төгрөгийн цалингийн урамшуулал олгосон байна. Мөн ЗДТГ-ын дарга өөртөө болон аймгийн орлогч даргад тушаал гарган, 4.9 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон;
- Хөдөлмөрийн тухай хуульд ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад тэтгэмж олгох асуудлыг тодорхой зохицуулсан байхад, ЗДТГ хөдөлмөрийн дотоод журамд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдад 1-3 сарын тэтгэмж олгох шийдвэр гаргаж, нийт 4.8 сая төгрөг зарцуулсан нь хууль тогтоомжийг зөрчсөн;
- Сүхбаатар сумын ЗДТГ нь биеийн тамирын арга зүйч, хэвлэл мэдээллийн ажилтан зэрэг төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдсон албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулахгүйгээр хөдөлмөрийн харилцаа үүсгэж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин олгон, сар бүр ур чадварын нэмэгдэлд 3.3 сая төгрөг олгосон;
- Мөнххаан сумын ЗДТГ биеийн тамирын арга зүйчийн албан тушаалын тодорхойлолтыг батлуулаагүй, хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй байхад ажлыг үнэлж үр дүнгийн урамшуулалд 1.3 сая төгрөгийг тус тус олгосон байна.

1.3.2.12 Дээрх зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3¹⁵ дах хэсэг, заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйл¹⁶, 47 дугаар зүйлийн 47.1¹⁷ дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1¹⁸ дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.5¹⁹, 41 дүгээр зүйлийн 41.2.2²⁰, 41.2.3²¹ - т заасныг зөрчсөнд төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

1.3.2.13 Төрийн аудитын байгууллагын 2020-2024 оны СТА-ийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд, төрийн байгууллагын удирдлагууд хууль,

¹⁵ Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд дайчлах, чиг үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

¹⁶ Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсэх нөхцөл

¹⁷ Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээ байгуулна.

¹⁸ Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана:

¹⁹ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

²⁰ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

²¹ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

тогтоомж зөрчиж, цалин, нэмэгдэл урамшуулал олгодог алдаа зөрчил гаргасан нь ажиглагдаж байна. Тухайлбал, статистик мэдээнээс цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой 110 зөрчилд 287.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

1.3.2.14 Төрийн албан тухай хуулийн *(2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар нэмсэн)* 57 дугаар зүйлийн 57.17 дахь хэсэгт төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгохоор тусгасан. Сүхбаатар аймгийн хэмжээнд орон нутгийн нэмэгдлийг МУЗГ-ын болон аймгийн ИТХ-ын тогтоолд заасан хувь хэмжээгээр тооцож улс, орон нутгийн төсвөөс 614.7 сая төгрөгийг олгосон байна. Мөн хуулийн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр үйлчилгээний болон улс төрийн албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэл олгож эхэлсэн бөгөөд 2024 оны төсвийн жилээс дээрх албан тушаалын орон тоонд ажиллаж байгаа албан хаагчид нэмэгдлийг олгож эхлээд байна. Хуулийн энэ заалт нь төрийн албанд ажиллаж байгаа залуучуудыг орон нутагт тогтвортой ажиллахад мэдэгдэхүйц нөлөөлсөн шийдвэр болсон байна.

1.3.2.15 Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5-д “орон байраар хангахад төрөөс дэмжлэг үзүүлнэ” гэж заасан боловч, санхүүгийн дэмжлэг батлагдаагүйгээс уг хуулийн зорилт тунхаглал төдий үлдэж, бодитой хэрэгждэггүй байдал нийтлэг байна. Төрийн албан хаагчдад орон байрны бодит дэмжлэггүй байх нь төрийн албанд залуучуудыг татах, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл, баталгаа болж чадахгүй байгааг харуулж байна.

Төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалттай холбоотой гомдол маргаан гараагүй байна.

1.3.3.1 Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд ТАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1²²-д заасан эрх бүхий этгээд дараах журмын дагуу нөхөхөөр тусгасан байна.

- Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс;
- Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас;
- Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог тухайн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс;

1.3.3.2 Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах” журмыг баталсан байна.

²² 27.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө.

1.3.3.3 Сүхбаатар аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн 2023 оны тайлангаас үзэхэд, төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх зорилгоор зарласан сонгон шалгаруулалтад оролцсон хамгийн өндөр оноо авсан 84 нэр дэвшигчийг томилуулах зөвлөмжийг тухайн байгууллагад хүргүүлснээс 81 нэр дэвшигчийг албан тушаалд томилсон байна. Харин дараах нөхцөл байдлаас шалтгаалан 3 нэр дэвшигчийг албан тушаалд томилоогүй байна. Үүнд:

1. ГБХЗХГ-ын зорилтот бүлгийн залуучууд, сургалт хариуцсан мэргэжилтэн, ХХҮГ-ын сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн мэргэжилтний албан тушаалд нэр дэвшигч өөрийн хүсэлтээр томилогдохоос татгалзсан байна.
2. Дарьганга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан тушаалд нэр дэвшигчийг ИТХ-ын дарга томилохоос татгалзсан.

1.3.3.4 Дарьганга сумын ИТХ-ын даргаас Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасны дагуу нэр дэвшигчийг томилохоос татгалзсан хариу ТАСЗ-д ирүүлсэн байна. Төрийн албаны салбар зөвлөл нэр дэвшигчийг томилохоос татгалзсан үндэслэл хуульд нийцээгүй гэж үзэж “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах” журмын 12.8-т заасны дагуу шийдвэрийг биелүүлэхийг даалгасан боловч шийдвэрийг хэрэгжүүлээгүй бөгөөд Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр 2024 оны 11 сард албан тушаалд томилогдсон байна.

1.3.3.5 Төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт, нөхөн томилгоотой холбоотой маргаан, гомдол аймгийн Засаг дарга, ТАСЗ-д ирээгүй байна.

1.3.3.6 Сүхбаатар аймгийн хэмжээнд Төрийн албан ерөнхий шалгалтын талаар мэдээлэлд 2019-2023 оны байдлаар дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарч байна. График 3



1.3.3.7 Сүүлийн 5 жилийн байдлаар давхардсан тоогоор 1,539 иргэн төрийн албаны ерөнхий шалгалтад орж 374 буюу 24.3 хувь тэнцсэн байна. Төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн иргэдээс 72.7 хувь нь төрийн албанд томилогдон ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учруулсан хохирол бүрэн төлөгдөөгүй байна

1.3.4.1 Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шийдвэрээр Сүхбаатар аймгийн хэмжээнд 2012-2023 онд захиргааны болон иргэний хэргийн шүүхээр 81 албан хаагчийн эрх зөрчигдөн ажлаас чөлөөлөгдсөн нь тогтоогдож, тэднийг эрхэлж байсан ажилд нь эргүүлэн томилох, мөн ажилгүй байх хугацааны цалин хөлсийг тухайн байгууллагаас гаргуулахаар шийдвэрлэсэн байна.

1.3.4.2 Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шийдвэрээр Сүхбаатар аймгийн хэмжээнд 2012-2023 онд захиргааны болон иргэний хэргийн шүүхээр 81 албан хаагчийн эрх зөрчигдөн ажлаас чөлөөлөгдсөн нь тогтоогдож, тэднийг эрхэлж байсан ажилд нь эргүүлэн томилох, мөн ажилгүй байх хугацааны цалин хөлсийг тухайн байгууллагаас гаргуулахаар шийдвэрлэсэн байна.

1.3.4.3 Төрийн албан тухай хуулийн 50 дугаар зүйлд төр учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих чиг үүргийг тусгаж, уг чиг үүргийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлэхээр хуульчилжээ.

1.3.4.4 Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд, 2016-2020 оны засаглалын хугацаанд төрийн албан хаагчийн эрх хамгийн их зөрчигдсөн байна. Энэ нь орон нутгийн сонгуулиар засаглах эрх авсан удирдах албан тушаалтнууд бүтэц, орон тоог шинэчлэх агуулгын дор ямар ч шалтгаангүйгээр албан хаагчдыг ажлаас халсантай холбоотой бөгөөд, үүнээс үүдэн төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, шүүхээс ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг олгох шийдвэр гаргаснаар төрд хохирол учрах үндсэн шалтгаан болсон байна.

1.3.4.5 Төрийн албан хаагчийн буруутай шийдвэрээс шалтгаалан төрд учирсан хохирлыг эрх бүхий байгууллага нэхэмжилж төлүүлсэн эсэхийг судлахад, 2023 оны байдлаар 218.6 сая төгрөгийг төлүүлэхээр нэхэмжилснээс 32.6 сая төгрөгийг төлсөн байна. Иймд төрийн албан хаагчийн эрхийг зөрчиж, буруу шийдвэр гаргасан нь тогтоогдсон албан тушаалтнаас төрд учруулсан хохирлыг нэхэмжлэх, төлүүлэх арга хэмжээг эрх бүхий байгууллагаас авах шаардлага үүссэн байна.

1.3.4.6 Харин 2012 оны 6 албан тушаалтны 3.7 сая, 2013 оны 1.2 сая, 2014 оны 8.6 сая төгрөгийн төрд учирсан хохирлыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаас нэхэмжлэх боломжгүй нөхцөл байдалд үүсээд байна. Энэ нь Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэгт хөөн хэлэлцэх ерөнхий хугацааг арван жил байхаар хуульчилсантай холбоотой байна.

1.3.4.7 ГХБХБГ-ын дарга ажил үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн гэх шалтгаанаар Халзан сумын газрын даамлыг ажлаас халах шийдвэр гаргасан бөгөөд шүүх төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн гэж үзэж ажилгүй байх хугацааны цалинг олгохоор тогтоосон байна. Шүүхийн шийдвэрийн дагуу газрын дарга тухайн албан хаагчид учруулсан хохирлыг төрөөс гаргахгүйгээр өөрөө хариуцсан төлсөн байна. Энэ нь тухайн удирдлага өөрийн буруутай шийдвэрийг хариуцсан, төрийн албаны зарчмыг баримталсан сайн жишээ болсон байна.

Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн санд албан хаагчийн мэдээллийг дутуу оруулах нийлэг алдаа гарч байна.

1.3.5.1 Төрийн албан хаагчийн мэдээллийг ТАЗ-ийн Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системд бүртгэж мэдээллийн санг бүрдүүлж байна.

1.3.5.2 Аймгийн хэмжээнд төрийн ихэнх байгууллага нь хүний нөөцийн ажилтны орон тоогүйгээс аль нэг албан тушаалтанд хүний нөөцийн ажлын чиг үүргийг хавсран гүйцэтгүүлж байна.

1.3.5.3 Төрийн албан хаагчийн хувийн хэргийн мэдээллийг ХНУМТ-ны системд бүрэн оруулж, мэдээллийн санг үүсгэсэн эхийг түүвэрчлэн тулган баталгаажуулалт хийхэд дараах нийтлэг алдаа илэрсэн байна Тухайлбал:

- Тухайн албан хаагчийн ажилд томилогдсон тушаал, шийдвэрийг үнэн зөв оруулаагүй байх;
- Эрэгтэй албан хаагчийн цэргийн үүрэгтний мэдээллийг дутуу оруулах;
- Ажилласан жилийн мэдээллийг зөрүүтэй оруулах;

1.3.5.4 Энэ нь хяналт тавих эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хэрэгжүүлээгүй, албан хаагч хувийн хэрэгт байвал зохих баримт материалыг дутуу бүрдүүлсэн зэргээс шалтгаалж байна.

1.3.5.5 Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дотоод хяналтын нэгж ХНУМТ-ны системийн мэдээлэлд хяналт хэрэгжүүлж, илэрсэн алдааг залруулан ажилласнаар үр дүнтэй ажил болсон байна.

1.3.5.6 Иймд төрийн байгууллагын дотоод хяналтын нэгж ХНУМТ-ны системд хяналт хэрэгжүүлж, дээр дурдсан нийтлэг алдаа болон зөрүүтэй оруулсан мэдээллийг засах, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлж, хүний нөөцийн ажилтантай хамтран ажиллах нь зүйтэй байна. Уг системд мэдээллийг иж бүрэн, алдаагүй оруулж хэвшихгүй бол мэдээллийн чанар, удирдлагын шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

БҮЛЭГ 2: Төрийн байгууллагууд жендерийн тэгш байдлыг хангах талаар тодорхой бодлого хэрэгжүүлээгүй, албан хаагчдыг сургах төлөвлөгөөг баталсан боловч, хэрэгжилтийг үр дүнтэй тайлагнаагүй, жилийн гүйцэтгэлийн тайланг үр дүнд тулгуурлан тайлагнах үйл явц хангалтгүй байгаагаас албан хаагчдын хөгжлийг дэмжих, тогтвортой ажиллах орчин бүрдүүлэхэд сөрөг үр дагавартай байна.

2.1 Төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, мэргэшсэн албан хаагчдыг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөө баталсан боловч, түүний хэрэгжилтийг тайлагнаагүй, төрийн албан хаагчдын 71.6 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.

Төрийн байгууллагууд 2012-2023 онд давхардсан тоогоор 4,505 албан хаагчийн сургалт хамруулсан бол мэргэшүүлэх багц сургалтад 122 албан хаагч хамрагдсан байна.

2.1.1.1 Хүний нөөцийн нэгдсэн судалгаанд хамрагдсан 3,282 албан хаагчийн боловсролын түвшинд харьцуулалт хийхэд 2,549 албан хаагч буюу 77.7 хувь нь дээд боловсролтой байна. Дээд боловсролтой албан хаагчдын 12.4 хувь нь хоёр их, дээд сургууль төгссөн бол 213 албан хаагч магистрын зэрэгтэй байна.

2.1.1.2 Төрийн байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөө болон дээд шатны байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн сургалтад 2012-2023 онд давхардсан тоогоор 4,505, гадаад сургалтад 68, мэргэжлийн давтан сургалтад давхардсан тоогоор 1,807 албан хаагч тус тус хамрагдсан байна.

2.1.1.3 Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна” гэж заасан бөгөөд энэ дагуу мэргэшүүлэх сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батлахаар хуульчилсан. Мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2²³-т заасны дагуу тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдохын тулд ажилласан жилийн шаардлагаас гадна мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх тусгай шаардлага тавигдсан байна.

2.1.1.4 ЗГХЭГ-ын дарга, ТАЗ-ийн даргын хамтарсан 2019 оны 37/33 дугаар тушаалаар “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”-ийг баталжээ. Уг хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар аймгийн төрийн захиргааны байгууллагын 122 албан хаагч (давхардсан тоогоор) багц сургалтад хамрагдсан байна.

²³ 23.2.Хуульд өөрөөр заагаагүй бол доор дурдсан төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 22.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан иргэнийг томилно:

23.2.1.тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох бол төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх бөгөөд мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх;

2.1.1.5 Төрийн байгууллагууд албан хаагчдыг ажлын байранд суралцах дотоод сургалтын төлөвлөгөөг жил бүр баталсан боловч хэрэгжилтийг тайлагнах ажил хангалтгүй байна.

2.1.1.6 Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс 2022 оноос “Шинэ ажилтныг дадлагажуулах” хөтөлбөрийг боловсруулан, шинээр томилогдсон албан хаагчдад ажлын баримжаа олгох, байгууллагын хэлтэс, тасагтай танилцах, хууль эрх зүйг судлуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь бусад байгууллагуудаас онцлог, сайн туршлага болж байна.

2.1.1.7 Иймд төрийн байгууллагууд шинээр томилогдож байгаа албан хаагчдыг дадлагажуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь тухайн албан хаагчийн ажлын байран дээр дадлагажих үр дүнтэй арга хэмжээ болох бөгөөд, шинэ ажилтнууд ажлын байранд шаардлагатай ур чадвар, мэдлэгийг хурдан эзэмшиж, байгууллагын үйл ажиллагаанд илүү үр бүтээлтэй оролцох боломжийг олгодог. Энэ арга хэмжээ нь байгууллагын ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлж, ажиллах орчныг сайжруулан, байгууллагын үйл ажиллагааг илүү үр дүнтэй, чанартай болгох боломжийг бүрдүүлэхээр байна.

Хууль, хүчний байгууллагын мэргэжлийн онцлогоос хамаарч, төрийн албан хаагчдыг сэлгэн болон шилжүүлэн ажиллуулж байна.

2.1.2.1 Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулахыг Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1²⁴ заалт, ЗГХЭГ-ын дарга, ТАЗ-ийн даргын хамтарсан 2019 оны 04 дүгээр сарын 01-ний 34/31 дугаар тушаалаар “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллах журам”-аар зохицуулагдаж ирсэн бөгөөд Төрийн албаны тухай хуульд /2022.07.05/-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 44 дүгээр зүйлийн 44.2²⁵ дахь заалтыг өөрчлөн, 44.5²⁶ заалтад нэмж нарийвчлан зааж өгсөн байна.

2.1.2.2 Төрийн байгууллагаас авсан судалгаагаар давхардсан тоогоор 544 албан хаагчийг сэлгэн болон шилжүүлэн ажилласан байна. Үүнээс хууль, хүчний байгууллагын 343 албан хаагчийг сэлгэн ажиллуулсан бөгөөд энэ нь цэргийн, цагдаагийн болон шүүх, прокурорын албан хаагчдыг нэг байгууллагад удаан жил ажиллуулахгүй, тогтмол сэлгэн ажиллуулдагтай холбоотой юм.

²⁴ 44.1. Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачилгаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн ажиллуулж болно.

²⁵ 44.2. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага хооронд тэдгээрийн удирдлага харилцан тохиролцсоны дагуу, эсхүл тухайн байгууллагын нэгж хооронд ажлын тодорхой чиглэлээр хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно.

²⁶ 44.5. Томилох эрх бүхий этгээд төрийн жинхэнэ албан хаагчид өөрт нь мэдэгдэн тухайн байгууллагын нэгж хооронд шилжүүлэн ажиллуулж болно.

Төрийн байгууллага өөрийн нөөц боломжид тулгуурлан мэдээлэл технологийн албан хаагчдыг сургалтад хамруулж байна.

2.1.3.1 Төрийн байгууллагуудын мэдээлэл, технологийн хүний нөөцөд дүн шинжилгээ хийхэд, 14 байгууллагын 11 албан тушаалд 11 албан хаагч ажиллаж байгаа бол, Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Нийгмийн даатгалын газар, Соёл урлагийн газарт тус бүр 1 орон тоо сул байна. Эдгээр байгууллагуудын мэдээлэл технологи хариуцсан албан хаагчид Удирдлагын академийн чиглүүлэх богино хугацааны сургалтад 3, мэргэшүүлэх дунд хугацааны болон давтан сургалтад тус бүр 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч давхардсан тоогоор хамрагджээ.

2.1.3.2 Мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн зөвлөх инженерийн сургалт, дотоодын их, дээд сургуулийн магистрын хөтөлбөр болон чадавхжуулах дотоодын богино хугацааны сургалтад албан хаагчид хамрагдсан бол Төрийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамжийн сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулан ажилласан байна.

Төрийн албанд жендерийн тэгш байдал харилцан адилгүй байгаа бөгөөд төрийн албан хаагчийн 71.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

2.1.4.1 Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дэх хэсэгт зааснаар ажил олгогчид жендерийн эрх тэгш байдлыг хангах үүргийг хүлээлгэсэн байна.

2.1.4.2 Төрийн албаны салбар зөвлөлд бүртгэлт нийт төрийн албан хаагчийн 71.6 хувийг эмэгтэй албан хаагч эзэлж байгаа бөгөөд энэ нь төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууллагад ихэвчлэн эмэгтэй албан хаагч ажиллаж байгаатай холбоотой байна. Энэ нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.6-т *(Хөдөлмөрийн тухай хуулийн 101.1 дэх хэсгийг хэрэгжүүлэх болон СӨБ байгууллага зэрэг байгууллагын ажил, үйлчилгээний онцлогоос хамаарч нэг хүйсийн хүний сонгох)* гэж заасантай нийцэж байна.

2.1.4.3 Аймаг, сумын ЗДТГ-т ажиллаж байгаа албан хаагчдын хүйсийн тэнцвэртэй байдлыг 2023 оны байдлаар авч үзэхэд, нийт албан хаагчийн тоо болон хуульд заасан харьцаа (60:40) хангагдаж байгаа бөгөөд эмэгтэй албан хаагч 46.3 хувийг эзэлж байна. Харин ЗДТГ тус бүрээр харьцуулахад, Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумын ЗДТГ-т эмэгтэй албан хаагчид 29.6-32.0 хувийг эзэлж байгаа бол, Түмэнцогт сумын ЗДТГ-ын эмэгтэй албан хаагчид 66.6 хувийг эзэлж байна.

2.1.4.4 Иймд, Баяндэлгэр, Түмэнцогт, Эрдэнэцагаан сумын ЗДТГ-ын удирдлага хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан хүйсийн харьцааг тэнцвэртэй байлгах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх нь зүйтэй байна

2.1.4.5 Аймгийн Засаг дарга жил бүр жендерийн салбарын хорооны эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийн тайланг сум тус бүрээс авч нэгтгэн мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8²⁷-т заасан хугацаанд Жендерийн үндэсний хороонд хүргүүлсэн байна.

2.1.4.6 Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 11.4.1²⁸ (ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод журамд тусгах)-т гэж заасны дагуу төрийн бүх байгууллага энэ талаар хөдөлмөрийн дотоод журамд тусган баталсан байна.

2.2 Төрийн захиргааны байгууллага гүйцэтгэлийн тайланг хүрэх түвшинд үндэслэн тайлагнаагүй, төрийн байгууллагын ил тод байдалд хяналт тавих олон нийтийн зөвлөл томилогдоогүй байна.

Е-Mongolia цахим системээр дамжуулан төрийн үйлчилгээг хүргэх нь иргэдийн бодит цагийг хэмнэх, хүнд сурталгүй болгох боломжийг олгож байна.

2.2.1.1 УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтоож, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлэх”, ЗГ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичигт “Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах” зорилт арга хэмжээг тусгажээ.

2.2.1.2 Уг зорилтын хүрээнд Сүхбаатар аймагт Төрийн цахим үйлчилгээний хэлтэс 2023 оны 7 сард байгуулагдаж дараах үйлчилгээг иргэдэд хүргэсэн байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг цахимаар иргэдэд хүргэх, зөвлөгөө мэдээллээр хангах ажлын хүрээнд 790 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн;
- Операторын системээр дамжуулан 2,582 иргэн иргэний үнэмлэх, нийгмийн даатгал төлөлт, оршин суугаа хаяг, гэрлэлтийн лавлагааг гаргасан;
- Төрийн 62 байгууллагын албан хаагчдад “төрийн цахим үйлчилгээг сурталчлах”, кибер аюулгүй байдлын сургалтыг хүргэсэн;
- Huduu.mn сайтад төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын 568 мэдээ мэдээллийг байршуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

2.2.1.3 Төрийн цахим мэдээллийн систем болох e-mongolia.mn дамжуулан лавлагаа мэдээллийг түргэн шуурхай авах боломж бүрдсэн нь иргэдийн цагийг

²⁷ төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллагсдын хүйсийн тэнцвэртэй байдлын тайланг сум, дүүргийн Засаг дарга дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг, нийслэлийн Засаг дарга дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор Жендерийн үндэсний хороонд тус тус хүргүүлэх;

²⁸ ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах;

хэмнэх, төрийн үйлчилгээг нэг дороос бүрэн авах сайн талтай боловч, иргэний хувийн мэдээллийг хэт ихээр хадгалж буй нь хувийн мэдээлэл алдагдах эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай. Мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалт хангалтгүй байгаагаас үүдэн хувийн мэдээлэл алдагдах, иргэдийн хувийн нууц хамгаалагдахгүй болох эрсдэл үүсэх асуудлыг оновчтой зохицуулан хамгаалах нь чухал юм.

2.2.1.4 Төрийн байгууллага хэрэгжүүлэх зорилт, чиг үүргийнхээ хүрээнд цахим программыг нэвтрүүлэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрчээ. Тухайлбал:

- *Аймгийн нэгдсэн эмнэлэг: Эмч эмнэлгийн ажилтны ажлын цагийг зохицуулах, ачааллыг тэнцвэржүүлэх, үйлчлүүлэгчийн цагийг хэмнэх зорилгоор үзлэгийн цагийг цахимаар олгосноор хэт их дараалал үүсэх байдал багассан;*
- *Газрын харилцааны мэдээллийг ил тод нээлттэй болгох зорилгоор e.gazar.gov.mn сайтыг нэвтрүүлснээр иргэд газрын талаарх мэдээллийг түргэн шуурхай авах хандлага нэмэгдсэн, газрын дуудлага худалгааг www.mle.mn сайтаар дамжуулан цахимаар зохион байгуулж байгаа нь Монгол улсын хаанаас ч дуудлага худалдаанд оролцох боломж нээгдсэн;*
- *Аж ахуйн нэгж байгууллага татварын тайлан мэдээг <https://etax.mta.mn/app/dashboard> дамжуулан хүргүүлж байгаа нь цаг хэмнэсэн, төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад ойртуулсан сайн туршлагауд болсон байна.*

2.2.1.5 Төрийн байгууллагад ашиглагдаж байгаа цахим программыг тухай бүр үе шаттай сайжруулалт, хөгжүүлэлт хийх шаардлагатай бөгөөд, улсын хэмжээнд ашиглагдаж байгаа программ хангамж нь оргил ачааллын үед гацалт үүсэх, мэдээллийг хүлээн авахгүй байх зэрэг хүндрэл үүсэж байна. Цахим программыг сайжруулах, хөгжүүлэх тогтвортой стратеги, төлөвлөгөөг боловсруулах, системийн ачааллыг зохицуулах хүчин чадлыг нэмэгдүүлэх нь төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэхэд үүсэх хүндрэлийг багасгаж, үйлчилгээний чанар болон үр дүнг дээшлүүлэх боломжтой юм.

Байгууллагын гүйцэтгэлийн тайланг зорилт, арга хэмжээ, хүрэх түвшинтэй уялдуулан тайлагнах ажил хангалтгүй хэрэгжиж байна

2.2.2.1 Хяналт-шинжилгээний, үнэлгээний хэлтсээс Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгч дүгнэсэн байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн байгууллагын үйлчилгээний цар хүрээнээс шалтгаалан 10-15 шалгуур үзүүлэлтээр дүгнэж үнэлсэн бөгөөд төрийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дундаж үнэлгээ 87.6 хувьтай гарсан байна.

Хүснэгт 9 ХШҮХ-ийн үнэлгээний дундаж

д/д	Байгууллагын төрөл	Үнэлгээ		
		2021 он	2022 он	2023 он
1	ЗДТГ (бүх шатны)	81.5	80.6	84.1
2	ЗДЭАХ-ний байгууллага	84.7	86.4	88.0

3	Төсвийн байгууллага	82.2	83.8	90.7
Дундаж үнэлгээ		82.8	83.6	87.6

2.2.2.2 Төрийн байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн байдлаас үзэхэд сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа дунджаас доогуур байна. Энэ нь ЗДТГ гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, бодлогын хэрэгжилтийг дутуу тайлагнадаг зэрэг нийтлэг алдаануудын нөлөөгөөр үүссэн байна.

2.2.2.3 Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг түүвэрчлэн дүн шинжилгээ хийхэд, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт, арга хэмжээнд хамааралгүй, эсвэл ижил утгатай төсөл, арга хэмжээ төлөвлөдөг, хэрэгжилтийг хүрэх түвшинтэй уялдуулж тайлагнадаггүй зэрэг алдаа, зөрчлүүд илэрч байна. Тухайлбал, аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланд дүн шинжилгээ хийж үнэлэхэд 42 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй тайлагнасан байна. Үүнээс түүвэрчлэн үнэлсэн байдлыг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 10 Аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ

№	Зорилт, аргахэмжээ	хэрэгжилт	ЗДТГ-ын үнэлгээ	Аудитын тайлбар
2022 он				
1.3.1	Аймгийн ахмадын бага чуулганыг зохион байгуулах	Монголын ахмадын холбооноос ирүүлсэн чиглэл ирүүлсний дараа аймгийн Ахмадын бага чуулган, Ахмадын хорооны тайлант сонгуулийг хамтатган зохион байгуулахаар болсон тул хойшлогдсон.	50 хувь	Зорилт арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүй
1.9.4	Халуун усны барилга шинээр барих Баруун-Урт сумын 4-р баг	Газрын байршил тодорхойгүй, зураг төсөлгүй, ИТХ-ын ээлжит хуралдаанаар хөрөнгө хасагдсан.	30 хувь	Зорилт арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүй
2.1.1	Аймгийн Засаг даргын Тамгын газарт магадлан аудит хийлгэх	Тайлант хугацаанд аймгийн нийт төрийн захиргааны байгууллагад 13012 өргөдөл гомдол, санал хүсэлт, талархал ирсний 12832 өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлт 95,5 хувийн үзүүлэлттэй байна.	100 хувь	Хэрэгжилт зорилт арга хэмжээтэй нийцээгүй
2023 он				
1.9.1	Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг Баруун урт хотын “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-д нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлэх	Сүхбаатар суманд Ёст бэйс сервис ХХК-ийн 4 айлын 165м2 орон сууцыг тус тус ашиглалтад оруулж улсын комисст хүлээлгэн өгсөн байна.	90 хувь	Хэрэгжилт зорилт арга хэмжээтэй нийцээгүй

1.17.5	Баруун-Урт сумын 3 дугаар сургууль, Онгон сумын ерөнхий боловсролын сургуульд цэрэг дайчдын “Алдын танхим” байгуулах	2023 онд Онгон сумын ЕБС, Баруун-Урт сумын 3 дугаар сургуульд байгуулахаар төлөвлөсөн ч шинэ сургуулийн байранд ороод байгуулахаар болсон	30 хувь	Зорилт арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүй

2.2.2.4 ЗДТГ гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой тайлагнаагүй байгаа нь ЗГХЭГ-ийн гүйцэтгэлийн тайланг үнэлсэн байдлаас тодорхой харагдаж байна. Тухайлбал, аймгийн ЗДТГ 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 90.87 хувьтай үнэлэсэн боловч, ЗГХЭГ-аас 78.86 хувь хэрэгжсэн гэж үзсэн байна.

НЭГДСЭН СТАТИСТИК & ТАЙЛАН :: ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН :: 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нийт зорилтын тоо	Нийт арга хэмжээний тоо	Үнэлгээ	Арга хэмжээний тоо	
			Өөрийн үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө	[файл]	100%	82	58
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	[файл]	90%	13	7
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ	[файл]	70%	10	25
		50%	4	13
		30%	6	8
		0%	-	4
		Дундаж	90.87%	78.8696%

Албан хаагчид бодитой тайлагнал хийдэггүй нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх системийн дутагдал, зорилт, арга хэмжээг тооцоо судалгаатай төлөвлөхгүй байх, мөн хүрэх үр дүнтэй уялдуулан үнэлгээ өгдөггүйтэй холбоотой байна. Энэ нь албан хаагчид болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ зөрүүтэй гарч, байгууллагын бодит үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн талаарх буруу ойлголт үүсэх, төрийн үйл ажиллагааны үр дүн, чанар буурах, төсвийн хөрөнгө зарцуулалтыг үр ашиггүй байлгах эрсдэл үүсгэхээр байна.

2.2.2.5 Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хүрэх түвшинтэй харьцуулан үнэн зөв, бодит байдалд нийцүүлж тайлагнаагүй байгаагаас албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэт өндрөөр үнэлж, урамшуулал олгож байгаа нь учир дутагдалтай байна. Иймээс хэлтсийн дарга, удирдлагууд гүйцэтгэлийн тайланг үнэлэхдээ хүрэх түвшин, дэвшүүлсэн зорилттой уялдсан эсэхийг үндэслэн үнэлж дүгнэх нь зүйтэй.

2.2.2.6 Байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэл буруу үнэлэгдэж, хэт өндөр үнэлгээ өгөх нь ирээдүйд бодит байдлын зөрүү үүсгэж, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулахад хүргэхээр байна. Мөн албан хаагчдын гүйцэтгэлийг бодитой үнэлэхгүйгээс тэдний бүтээмж буурах, төрийн үйлчилгээний чанарт нөлөөлж, иргэдийн сэтгэл ханамж алдагдах магадлалтай байна.

2.3 Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хяналт тавих олон нийтийн зөвлөл томилогдоогүй байгаа ч, төрийн байгууллагууд чиг үүргийнхээ дагуу хамтран ажиллаж байна.

Төрийн байгууллагууд үйл ажиллагааны чиглэлийн дагуу хамтран ажиллаж байна.

2.3.1.1 Аймгийн Засаг дарга нь сумын Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагатай гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, холбогдох сайд, яам, агентлагтай гурвалсан гэрээ байгуулан, төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэх ажлыг хамтран зохион байгуулж байна.

2.3.1.2 Сүхбаатар аймгийн хэмжээнд төрийн байгууллагууд ERP цахим системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, мэдээлэл, албан бичгийг харилцан солилцож байна. Энэ нь аймаг, орон нутагт мэдээллийг албан хаагчдад түргэн шуурхай хүргэх боломжийг олгож, иргэдэд үйлчилгээг үзүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

2.3.1.3 Төрийн байгууллагууд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй уялдуулан хамтран ажиллаж байна. Тухайлбал:

- *ХХҮГ-ийн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн хүрээнд мэргэжил олгох сургалтыг Мэргэжлийн боловсролын сургуультай хамтран зохион байгуулж байгаа бол ГБХЗХГ-тай залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байна.*
- *Зэвсэгт хүчний 338 дугаар анги хугацаат цэргийн албан хаагчийг Мэргэжлийн боловсролын сургуулийн мэргэжил олгох богино хугацааны хөтөлбөрт хамруулж мэргэжлийн үнэмлэхтэй болгосон байна.*

2.3.1.4 Харин аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс нь орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх талаар уялдаа холбоотой ажилладаг хэдий ч Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т /Татварын алба нь энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр татвар төлөгчийн мэдээллийг бусдад өгөх, эсхүл хувийн зорилгоор ашиглах байдлаар задруулахыг хориглоно./ заасны дагуу Санхүү, төрийн сангийн хэлтсээс иргэн, хуулийн этгээдийн татвар төлөлтийн мэдээлэл татан авч төсвийн орлогын төлөвлөгөөг бодитой тооцоо судалгаанд тулгуурлан хийх нөхцөл боломж нь хязгаарлагдаж байна.

2.3.1.5 Иймд дээрх хуульд өөрчлөлт оруулж харилцан хамаарал бүхий байгууллагад хуулийн этгээдийн татвар төлөлтийн талаарх мэдээллийг авч тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийх боломжийг олгох нь зүйтэй байна.

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавих орон тооны бус зөвлөл томилогдоогүй байна.

2.3.2.1 Төрийн албаны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д (*Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ.*) заасан байна.

2.3.2.2 Мөн хуулийн 56.2-т заасны дагуу Төрийн албан зөвлөлийн 2021 оны 212 дугаар тогтоолоор Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийг баталсан байна. Харин Сүхбаатар аймагт тус бүрийн 3 дугаар зүйлд заасны дагуу орон тооны бус хяналтын зөвлөлийг томилон ажиллуулаагүй байна.



Холбогдох байгууллагын санал



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛ

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512292

2024.12.03 № 59
танай _____-ны № _____-т

「 СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН 」
АУДИТЫН ГАЗАРТ

“Төрийн байгууллагын хүний нөөцийн
бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд оруулах
саналгүй болно.

ДАРГА



Х.ЭНХЦЭЦЭГ

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

Аймгийн ИТХ-ын бүтэц, орон тоог Засгийн газрын тогтоолтой уялдуулан батлаагүй, Төрийн албаны салбар зөвлөл болон ЗДТГ нь хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хүний нөөцийн бодлогын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадаагүй байна.

Эрүүл мэндийн салбарт 10,000 хүн амд ногдох эмч, сувилагчийн тоо улсын дунджаас доогуур байгаа нь иргэд эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг хязгаарлаж, үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулж байна.

Газрын даамалгүй сумдын иргэд газар өмчлөх эрхээ эдлэх боломжгүй болж, хуульд заасан эрх нь зөрчигдөж байна. Иймд орон тоог нөхөх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, хуульд нийцүүлсэн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Баруун-Урт сумын ЗДТГ-ын албан хаагчдын хэрэгжүүлэх чиг үүрэг давхардсан, төрд учруулсан хохирлыг эрх бүхий албан тушаалтнууд төлөөгүй, мөн төсвийн хүрэлцээ хангамж дутагдалтайгаас төрийн албан хаагчдын нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсжээ.

Төрийн байгууллагууд жендерийн тэгш байдлыг хангах талаар тодорхой бодлого хэрэгжүүлээгүй, албан хаагчдыг сургах төлөвлөгөөг баталсан боловч, хэрэгжилтийг үр дүнтэй тайлагнаагүй байна.

Төрийн захиргааны байгууллагууд гүйцэтгэлийн тайланг хүрэх түвшинтэй уялдуулан бодитой тайлагнаагүй нь хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааны чанарт сөргөөр нөлөөлж, төрийн үйл ажиллагааны үр дүнг бууруулах эрсдэл үүссэн байна.

Төрийн байгууллагын ил тод байдалд хяналт тавих Олон нийтийн зөвлөл байгуулагдаагүйгээс иргэдийн хяналт сулрах, ил тод байдлыг хангах үйл явц хангалтгүй хэрэгжих нөхцлийг бүрдүүлж байна.

Төрийн байгууллагууд цахим программ нэвтрүүлж, үйл ажиллагаагаа автоматжуулснаар иргэдийн цагийг хэмнэж, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чухал үр дүнд хүрсэн байна.

Аймаг, сумдын ЗДТГ-ын бүтэц, орон тоог баталсан Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, албан тушаалуудыг тодорхой болгон, зохион байгуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Засаг даргад:

1. Төрийн албаны тухай хуульд заасан нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт төрийн албан хаагчдыг адил, тэгш боломжоор хангагдах нөхцөлийг бүрдүүлэх.
2. Төрийн албаны чанар, хүртээмж, ил тод байдалд хяналт тавих олон нийтийн зөвлөлийг томилон ажиллуулах шаардлагатай
3. Аймгийн Засаг даргын тамгын газрын даргыг томилсон шийдвэрт өөрчлөлт оруулж хуульд заасан хугацаатай томилох

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад:

1. Албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг хүрэх үр дүнтэй уялдуулан үнэлж, урамшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
2. Төрийн албан хаагчдыг үндсэн чиг үүргээс өөр ажил гүйцэтгүүлэхээр томилон ажиллуулахгүй байхыг зохион байгуулах.

Төрийн албаны салбар зөвлөлд:

1. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих.
2. Хууль заасан бүрэн эрхийн хүрээнд хүний нөөцийн бодлогод хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх

Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал:

Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийг сайжруулах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангахын тулд дараах хуулиуд болон эрх зүйн актуудад өөрчлөлт оруулах санал дэвшүүлж байна:

1. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах:

- Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нарийвчилсан журам боловсруулах заалтыг тодорхой болгох
- Салбар зөвлөлийн бүрэн эрхийг нэмэгдүүлж, хяналт-шинжилгээний үйл ажиллагааг зохицуулах механизм нэмэх.

2. Монгол Улсын Засгийн газрын тогтоолуудад тодотгол хийх

- Төрийн албан хаагчийн орон тоо, бүтэц, зохион байгуулалтыг тогтоохдоо албан тушаал бүрийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлж, давхардлыг арилгах
- Жишиг нормативыг оновчтой болгох, сум, аймгийн түвшний ялгаатай хэрэгцээг тусгах.

3. Хүний нөөцийн стратеги, хяналт-шинжилгээний журмыг батлах:

- Засгийн газрын тусгай журмаар хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг үнэлэх аргачлал, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох
- Удирдамж, арга зүйг үе шаттай боловсруулж, нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэх.

4. Зохион байгуулалтын өөрчлөлт:

- Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс төрийн байгууллагуудад зориулсан мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгох
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг төрийн байгууллагын үйл ажиллагаанд шууд тусгах механизм бий болгох.

Эдгээр өөрчлөлт нь төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг сайжруулж, үр нөлөөг дээшлүүлэх, давхардлыг арилгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг оновчтой болгоход чиглэнэ.